**ЗАГВАР 10: АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ЗАГВАР**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

## Өвөрхангай аймгийн "Өв Эко Мийт" ОНӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2023/13/НА-СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өвөрхангай аймаг, Арвайхээр сум<br>2023 он | Тэргүүлэх аудитор: О.Батжаргал<br>Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Гансүх<br>Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com<br>Аудитор: Ж.Нямаа<br>Утас: 99327992 Цахим хаяг: Nyamaa.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023. 03. 24 № 150

танай ____________-ны №____________-т

"ӨВ ЭКО МИЙТ" ОНӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.ГАНСҮХ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Өв Эко Мийт" ОНӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ..

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Өв Эко Мийт" ОНӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Кассаар 25968.1 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээ хийсэн боловч 1872.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээний баримтын бүрдэл дутуу, 4333.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээний анхан шатны баримт байхгүй , нярав 3 удаа солигдсон, кассын орлогыг харилцах дансанд тушаадаггүй бэлэн зарцуулдаг, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй.
2. Тайлант онд бүртгэлтэй 294699.4 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4"Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно', 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн, СТОУС-ын 1, 16-д нийцэхгүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

0150307б2

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн тухай санхүүгийн тайландаа тодруулсан зүйл байхгүй.

**Аудитын гол асуудал**

Мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй , удирдлага, нягтлан бодогч, эд хариуцагчийн ажлын уялдаа холбоо муу, анхан шатны баримтгүй гүйлгээ бүртгэдэг, бэлэн мөнгөөр гүйлгээ их хийдэг, эд хариуцагч анхан шатны баримт бүрдүүлж тайлан гаргадаггүй , нягтлан бодогч хяналт тавьдаггүй ,өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмж хэрэгжээгүй алдаа зөрчил дахин давтан гарсан.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 67049.3 мянган төгрөгийн борлуулалт хийж 197232.8 мянган төгрөгийн зардал гаргаж 130183.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан. Нөөцийн махны санхүүжилтээр 144500,0 мянган төгрөгийн санхүүжилт авч 19 тн мах бэлтгэсэн.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 6,693,200.59 | 659,795.96 |
| 1.1.2 | Дансны авлага | 53,501,580.00 | 48,398,357.1 |
| 1.1.4 | Бусад авлага | 0.0 | 1,450,000.0 |
| 1.1.6 | Бараа материал | 4,214,939.57 | 123,361,921.3 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 28,475,600.0 | 11,639,670.0 |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | 92,885,320.16 | 185,509,744.33 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 2,826,410,936.50 | 1,901,263,320.22 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,394,000.00 | 921,015,012.08 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | 2,827,804,936.50 | 2,822,278,332.30 |
| 1.3 | **Нийт хөрөнгийн дүн** | 2,920,690,256.66 | 3,007,788,076.63 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 0.0 | 167,389,400.0 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 0.0 | 662,984.0 |
| 2.1.1.3 | Татварын өр | 5,690,732.80 | 12,269,524.94 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 11,562,763.40 | 4,213,007.74 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 475,167,100.0 | 525,167,100.0 |
| 2.1.1.13 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | 492,420,596.20 | 709,702,016.68 |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | 492,420,596.20 | 709,702,016.68 |
| 2.3 | **Өмч** | 3,060,057,600.0 | 3,060,057,600.0 |
| 2.3.1 | -төрийн | 3,060,057,600.0 | 3,060,057,600.0 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | -631,787,939.54 | -761,971,540.05 |
| 2.3.11 | **Эздийн өмчийн дүн** | 2,428,269,660.46 | 2,298,086,059.95 |
| 2.4 | **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | 2,920,690,256.66 | 3,007,788,076.63 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 204,537,971.00 | 67,049,315.0 |
| 2.0 | Борлуулалтын өртөг | 194,417,921.0 | 9,125,929.10 |
| 3 | **Нийт ашиг ( алдагдал)** | 10,120,050.0 | 57,923,385.90 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 395,018,898.0 | 188,106,985.9 |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | -384,898,847.99 | -130,183,600.0 |
| 20 | **Татварын дараахь ашиг (алдагдал)** | -384,898,847.99 | -130,183,600.0 |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | -384,898,847.99 | -130,183,600.0 |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1.1 | **Мөнгөн орлогын дүн** | 204,537,900.0 | 280,160,183.0 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 204,537,900.0 | 67,049,315.0 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 0.0 | 213,110,868.0 |
| 1.2 | **Мөнгөн зарлагын дүн** | 291,060,500.0 | 281,793,587.6 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 122,083,300.0 | 100,153,584.0 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 25,630,800.0 | 30,000,000.0 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 89,839,400.0 | 133,813,931.5 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 6,542,200.0 | 11,978,340.1 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 942,000.0 | 3,710,931.0 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 1,518,500.0 | 610,000.0 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 44,504,300.0 | 1,526,801.00 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | -86,522,600.0 | -1,633,404.6 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.0 | 4,400,000.0 |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | -36,321,800.0 | -4,400,000.0 |
| 4.1 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | -122,844,399.4 | -6,033,404.63 |
| 5 | **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | 129,537,600.0 | 6,693,200.59 |
| 6 | **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | 6,693,200.6 | 659,795.96 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| № | Үзүүлэлт | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 8 | **20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | 3,060,057,600.0 | -246,889,091.55 | 2,813,168,508.5 |
| 2 | **Залруулсан үлдэгдэл** | 3,060,057,600.0 | -246,889,200.0 | 2,813,168,508.5 |
| 3 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.0 | -384,898,847.99 | -384,898,848.0 |
| 8 | **2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | 3,060,057,600.0 | -631,787,939.54 | 2,428,269,660.46 |
| 2 | **Залруулсан үлдэгдэл** | 3,060,057,600.0 | -631,787,939.5 | 2,428,269,660.46 |
| 3 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.0 | -130,183,600.0 | -130,183,600.00 |
| 8 | **2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | 3,060,057,600.0 | -761,971,540.05 | 2,298,086,059.95 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 1220.5 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс 919.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж 300.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эзэмших эрхтэй газрыг | 1 | 919.6 | | | 1 | 919.6 | 1 | 919.6 | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| бусад үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 919.6 | 1 | 919.6 | | | 1 | 919.6 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Кассаар их хэмжээгээр бэлэн мөнгө зарцуулдаг боловч анхан шатны баримтын бүрдэл дутуу | 1 | 6.2 | | | 1 | 6.2 | | | | | | |
| Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй | 1 | 294.7 | | | 1 | 294.7 | | | | | | |
| Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж хэрэгжээгүй | | | | | | | | | 1 | | | |
| ДҮН | 3 | 300.9 | | | 2 | 300.9 | | | 1 | | | |

---

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |